**ГУРВАНСАЙХАН АВЛИГАТАЙ ТЭМЦЭХ ҮНДЭСНИЙ**

**ХӨТӨЛБӨРИЙН ХЭРЭГЖИЛТ**

(2018 оны жилийн эцсийн байдлаар )

2018.12.22

| № | Хөтөлбөр/төслийн агуулга | Гүйцэтгэл |
|---|---|---|
| 1. | Төсөл, хөтөлбөрийн нэр, огноо, шийдвэрийн дугаар (Жич: уялдаа холбоо бүхий дэд/төсөл, хөтөлбөр байвал нэгтгэн тайлагнана). | Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр |
| 2. | Санхүүжилтийн эх үүсвэр | Улсын төсөв |
| 3. | Хэрэгжүүлэгч байгууллага/ хэрэгжих нийт хугацаа | Үндсэн : Сумын ЗДТГазар<br>Хамтран хэрэгжүүлэгч байгууллага: Сумын төрийн байгууллагууд, албан хаагчид |
| 4. | Төсөл, хөтөлбөрийн зорилтууд | **Зорилт** 1.Шударга хариуцлагатай ил тод нийтийн албыг бэхжүүлэх замаар авлигын эрсдэлээс урьдчилан сэргийлэх төрийн жинхэнэ албан хаагчийн сонгон шалгаруулалт болон томилгоонд улс төрийн нөлөөллөөс ангид, мэдлэг, боловсролд суурилсан мерит зарчмыг хэрэгжүүлэх .<br><br>**Зорилт 2. Хоёр: Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг сайжруулах үйлчлүүлэгчдийн эрх ашгийг дээдэлж , төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**<br><br>**Зорилт 3: Төсөв санхүүгийн үйл ажиллагааны удирдлага хяналтыг сайжруулах ил тод байдлыг хангах төсвийн хөрөнгө гадаадын зээл тусламжийн үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр** |

| | | | | | |
|---|---|---|---|---|---|
| | | | **Зорилт 4: Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлж хяналт хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**<br><br>**Зорилт 5: Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга , ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх , авлигын эсрэг хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр**<br><br>**Зорилт 6: Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн хяналт иргэний нийгмийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр**<br><br>**Зорилт 7: Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр** | | |
| 5. | Зардал | Төсөв (нийт шаардагдах зардал) | | | |
| | | Үүнд: | Төсөв (он) | Гүйцэтгэл | Хувь |
| 6. | Төсөл, хөтөлбөрийн зорилт: | | Ажлуудын биелэлтийг доорх талбарт бичнэ. | | |
| | 1-р зорилтын хүрээнд:<br><br>Хүрэх үр дүн 1: Төрийн ажил үйлчилгээ нээлттэй ил тод болж, авлига ашиг сонирхлын зөрчилгүй ажиллах. | | 2018 онд нийтийн албанд томилогдохоор нэр дэвшсэн 1 албан хаагчийн ХАСУМ-ийг гаргуулан АТГ-т хүргүүлж, дүгнэлтийн дагуу томилж ажилласан. АТГ-ын дүгнэлтийг цахим хуудас болон мэдээллийн самбарт байршуулан ажиллаж байна. ХАСУМ-ийг хянуулалгүйгээр томилсон ажлын байр байхгүй болно. Нөөцийн бүртгэлийг шаардлагатай үед цахимаас татан үзэж аймгийн ТАСЗ-тэй хамтран ажилладаг. Албан хаагч бүртэй ёс зүйн гэрээг байгуулан , ажил дүгнэх үзүүлэлтэнд оруулан дүгнэж ажилладаг. Сумын ёс зүйн хороог нийт төрийн албан хаагчдын саналын дагуу байгуулсан. Байгууллагын Дотоод хяналтын нэгжийг ажиллуулан 2 удаа хяналт шалгалтыг зохион байгуулан ажилласан. Хууль бус шийдвэр гараагүй болно. 2018 оны сард 05 сард аймгийн ТЗУХ, ХЭЗХ-тэй хамтран Авлигын эсрэг хуулийн сургалтыг зохион байгуулж 86 төрийн албан хаагчдыг хамруулсан. | | |

| | | |
|---|---|---|
| | | Удирдах ажилтнуудын хамаарал бүхий судалгааг гарган мэдээллийн самбар, цахим хуудсаар иргэдэд мэдээлж ажилладаг. 100% |
| | 2-р зорилтын хүрээнд: **Төрийн үйлчилгээний нээлттэй байдлыг хангаж, цахим үйлчилгээг хөгжүүлж чанар хүртээмжийг сайжруулах үйлчлүүлэгчдийн эрх ашгийг дээдэлж , төрийн албан хаагчийн хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**<br><br>Хүрэх үр дүн 1: Төрийн байгууллагын нээлттэй байдал ил тод болж, цахимаар иргэд мэдээлэл авах боломж нөхцөл бүрдэж, албан хаагчдын ажлын хариуцлага дээшилнэ. | Байгууллагын дотоод хяналтын нэгжийг байгуулан урьдчилан сэргийлэх хяналт, шалгалтыг зохион байгуулан ажилладаг. Иргэдээс ирсэн санал өргөдөл гомдлыг тухай бүрт хуулийн хугацаанд шийдвэрлэн СӨГ-н мэдээг аймгийн ЗДТГ-т улирал бүр хүргүүлэн ажиллаж байна. Сумын хэмжээнд ХАСХОМ гаргадаг албан хаагчид цахимаар мэдүүлгээ гаргаж ажилладаг. . Албан хаагч бүрээр ажил дүгнэж үнэлэх үзүүлэлтийг гарган тайланг хамгаалуулж үнэлгээ өгч ажиллаж байна.<br><br>Гарын авлага боршурыг гарган 45 албан хаагчид , 62 иргэдэд тараан ажилласан. 70% |
| | 3-р зорилтын хүрээнд: **Төсөв санхүүгийн үйл ажиллагааны удирдлага хяналтыг сайжруулах ил тод байдлыг хангах төсвийн хөрөнгө гадаадын зээл тусламжийн үр ашигтай зориулалтын дагуу зарцуулах хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**<br><br>Хүрэх үр дүн 1:Төсөв санхүүгийн ил тод нээлттэй байдал бий болж төсвийн | 2018 онд Соёлын төвд 1100.00 төгрөгний тоног төхөөрөмж, Цэцэрлэгт 500.000 төгрөгний тоглоом, ЭМТөвд 2000.000 төгрөгний өвчтний өрөөний тохижилт зэрэг хандив тусламж ирсэнийг иргэдэд мэдээлж ил тод байдлыг ханган ажилласан.<br><br>Хандив тусламжийг www.shilendans.com аймгийн сайт болон сумын цахим сайт, мэдээллийн самбарт байршуулж олон нийтэд мэдээлж байна. 2017 оны жилийн эцсийн байдлаар 144336000 төгрөгний 10 8 бараа, 2 ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг сумын ИТХ-р батлуулсан бөгөөд 2018.01.05 өдрийн байдлаар **10** худалдан авалтын 144336000 төгрөгийн худалдан авалтанд 1375490 төгрөгийн гэрээ байгуулагдаж 6787000 төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Нийт зохион байгуулсан 10 худалдан авалтаас 7 тендер буюу 70 хувийг цахим |

| | | |
|---|---|---|
| | зарцуулалтын зөрчил дутагдалгүй ажилласан байх. | хэлбэрээр зарлаж зохион байгуулсан байна. Төсвийн ерөнхийлөн захирагчид аудитын дүгнэлтээр зөрчилгүй . Төсвийн байгууллагууд 2016 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын дүгнэлтийг бүрэн эрхээр нь аймгийн болон өөрийн байгууллагын сайт, мэдээллийн самбартаа байрлуулж, мэдээлэх ажил тогтмолжсон. Мэдээллийн самбараар 100 хувь мэдээлж, цахим хуудсанд 100 хувь байрлуулаад байна. 100% |
| | Зорилт 4: **Худалдан авах ажиллагааны эрх зүйн зохицуулалтыг боловсронгуй болгож, үр ашигтай, шударга, ил тод нээлттэй байдлыг нэмэгдүүлж хяналт хариуцлагыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**<br><br>**Хүрэх үр дүн: ХАА-ны ил тод болж иргэдэд мэдээлэл хүрсэн байх** | 2017 оны жилийн эцсийн байдлаар 144336000 төгрөгний 10 8 бараа, 2 ажил, үйлчилгээ худалдан авах төлөвлөгөөг сумын ИТХ-р батлуулсан бөгөөд 2018.01.05 өдрийн байдлаар **10** худалдан авалтын 144336000 төгрөгийн худалдан авалтанд 1375490 төгрөгийн гэрээ байгуулагдаж 6787000 төгрөгийн хэмнэлт үүссэн байна. Нийт зохион байгуулсан 10 худалдан авалтаас 7 тендер буюу 70 хувийг цахим хэлбэрээр зарлаж зохион байгуулсан байна. Хуулийн дагуу аймгийн www.dundgovi.gov.mn www.e-procurement.mof.gov.mn,орон нутгийн хөгжлийн сан цахим хуудсууд болон байгууллагын мэдээллийн самбарт байршуулж тогтмол шинэчилж байсан. 10 худалдан авалтын гүйцэтгэгчийг сонгон шалгаруулсан үндэслэл, үр дүнг Засгийн газрын худалдан авах ажиллагааны цахим хуудас /www.e-procurement.mn/-д тухай бүр нь байршуулсанДүгнэлт гарсан тухай бүрwww.shilendans.com Дундговь сайт болон мэдээллийн самбараар олон нийтэд мэдээлэж, мэдээллийг иргэд, байгууллага чөлөөтэй авах нөхцөлөөр хангаж ажилласан. 2017 онд хууль болон холбогдох журамд заагдсан шаардлагыг хангасан 3 хүний бүрэлдэхүүнтэй 1 үнэлгээний хороо байгуулагдаж хуульд заагдсан чиг үүргийг хэрэгжүүлэн ажилласан байна. Үнэлгээний хорооны бүрэлдэхүүнд худалдан авах ажиллагааны чиглэлээр мэргэшсэн А-3 гэрчилгээ бүхий гишүүд 100 хувь хуульд зааснаар иргэний нийгмийн байгууллагын төлөөлөл ажиллаа. 100% |
| | Зорилт 5: **Шүүх эрх мэдлийн болон хууль сахиулах байгууллагын шударга , ил тод, хараат бус байдлыг бэхжүүлэх , авлигын эсрэг** | ХАСХОМ –ийг гаргадаг 7 албан хаагчдаас цахимаар мэдүүлгийг авч баталгааны маягтаар баталгаажуулан ажилладаг. 100% |

| | | |
|---|---|---|
| | **хамтын ажиллагааг сайжруулах зорилтыг хангах чиглэлээр**<br><br>**Хүрэх үр дүн: Сургалтанд хамрагдаж, цахим бүртгэл хийгдсэн байна.** | |
| | Зорилт 6: **Авлигаас урьдчилан сэргийлэх үйл ажиллагаанд иргэд олон нийтийн хяналт иргэний нийгмийн байгууллагын үүрэг оролцоог нэмэгдүүлэх идэвх санаачилгыг дэмжих зорилтыг хангах чиглэлээр**<br><br>**Хүрэх үр дүн: ТББ-ын хамтын ажиллагаа сайжирч, ажил гүйцэтгэсэн байх** | Ахмад, Эмэгтэйчүүдийн ТББ-тай хамтран ахмадын баяр, эмэгтэйчүүдийн чуулганыг хамтран зохион байгуулж ажилласан. Төсвөөс олгож байгаа санхүүжилтийг мэдээллийн самбар болон тайланд тусган нээлттэй ажилладаг. Удирдах албан тушаалтнуудын хамаарал бүхий этгээдүүдийн судалгааг улирал бүр гарган мэдээллийн самбар, цахим сайт, мэдээллийн телевизээр иргэдэд хүргэн ажиллаж байна. 4-р улирлын байдлаар хамаарал бүхий 5 хамаарал бүхий этгээд байгаа судалгаа гарсан. Сургуулийн сурагчдад Авлигын эсргэр хуулиар сургалт явуулж шагнал урамшуулалд 60.000 төгрөгийг зарцуулсан. 70% |
| | Зорилт 7: **Шударга ёсны үзэл санааг төлөвшүүлэх олон нийтийг соён гэгээрүүлэх үйл ажиллагааг үе шаттай зохион байгуулж авлигын эсрэг боловсролыг дээшлүүлэх зорилтыг хангах чиглэлээр**<br><br>**Хүрэх үр дүн: Албан хаагчид хуулийн мэдлэгтэй болж, авлигын зөрчилгүй ажиллах** | Авлигын эсрэг тухай хуулиар албан хаагчдад сургалт зохион байгуулж сургалтанд хамрагдсан албан хаагчдаас байгууллагын хэмжээнд " Авлигыг цээрлэе, Ард түмнээ дээдлэе" уриаг гарган ил тод байршуулан ажиллаж байна. Авлигын эсрэг сургалтын гарын авлага бэлтгэн 32 төрийн албан хаагчдад тараан ажилласан. 70% |
| 7. | Дүгнэлт (ололт, дутагдал, анхаарах асуудлууд) | |
| 8. | Төсөл, хөтөлбөрийг хэрэгжүүлэгч талуудын хамтын ажиллагаанд өгөх хөндлөнгийн үнэлгээ | |

| | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| 9. | Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн үнэлгээ, дүгнэлт (өөрийн үнэлгээ) | Биелэлт дундаж | Зорилтын тоо | Зорилт 1 | Зорилт 2 | Зорилт 3 | Зорилт 4 | Зорилт 5 | Зорилт 6 | Зорилт7 |
| | | 82.5% | 7 | 100% | 70 % | 100% | 100% | 100% | 70% | 70% |
| 10. | Төсөл, хөтөлбөрийн хэрэгжилтийн нэгдсэн үнэлгээ (ЗГХЭГ-ын үнэлгээ) | Нэгдсэн үнэлгээ | | | | | | | | |
| | | 87 % | | | | | | | | |

ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗАР